



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 05 өдөр

Дугаар A/383

Булган сум

Г Зэвсэгт хүчний 337 дугаар ангид
хүндэтгэл үзүүлэх тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор Монгол Улсын Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын харьяа 337 дугаар ангийг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын баатар, Зөвлөлт Холбоот Улсын баатар, "Чингис хаан" тэргүүн зэргийн одонт, сансрын нисгэгч, хошууч генерал Жүгдэрдэмидийн Гүррагчаагийн нэрэмжит болгож байгаатай холбогдуулан хүндэтгэл үзүүлсүгэй.

2. Шаардагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс гаргахыг Аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Наранбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ЛҮРЭВ-ОЧИР